

АЗ ЖАРГАЛ БОЛОН САЙН ҮЙЛИЙН ТУХАЙ АРИСТОТЕЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ БА ОРЧИН ҮЕ

Р.Дарьхүү (Доктор PhD, профессор)


В.Мөнх-Уянга (Магистрант)

МУИС, ШУС, Философи, шаашин судлалын тэнхим

Түлхүүр үгс: Дээд сайн сайхан, сэтгэл ханамж, оюунлаг сайн үйл, ёс суртахуунлаг сайн үйл

Товч утга: Энэхүү өгүүлэлдээ тухайн цаг үеийнхээ мэдлэгийн нэвтэрхий толь болж байсан Аристотель ёс зүйн сэтгэлгээний талбарт ч нэрт сэтгэгч байсан бөгөөд тэрээр аз жаргал болон сайн үйл гэж юу болох тухай, хүний амьдралын зорилго бол аз жаргалтай амьдрах явдал бөгөөд аз жаргалтай амьдрахын тулд сайн сайхан зүйлд тэмүүлж, сайн үйл хийх ёстой гэсэн үзэл санааг ёс зүйн асуудлаар бичсэн бүтээлүүддээ хэрхэн тайлбарласан, түүний энэ үзэл баримтлалын орчин үеийн ач холбогдлыг тодорхойлохыг зорилго болгов.

* * * * *



Аристотель ёс зүйн асуудлаар тусгайлан бичсэн “Дээд суртахуун”, “Никомахын ёс зүй”, “Евдемийн ёс зүй” гэсэн гурван бүтээл байгаа нь түүний философид ёс суртахууны асуудал чухал судлагдахуун болж байсныг гэрчилнэ. Эдгээр сонгодог бүтээл бидний судалгааны үндсэн эх сурвалж болов. Түүний боловсруулсан ёс суртахууны философийн тулгуур ойлголтууд нь аз жаргал, сайн үйл хэмээх ойлголтууд болно. Тэрээр аз жаргал бол сайн үйлд нийцсэн амьдрал, үйл ажиллагаа болох тухай, аз жаргалд хүрэх арга хэрэгсэл бол сайн үйл болох тухай асуудлыг дэлгэрэнгүй тайлбарлажээ. Аз жаргал болон сайн үйлийн тухай Аристотелийн үзэл баримтлалыг судлах нь олон талын ач холбогдолтой.

Орчин үед аз жаргал болон сайн үйлийн талаарх ёс зүйн уламжлалт үзэл баримтлалыг судлах, түүнээс суралцах хэрэгцээ шаардлага өсөн нэмэгдэж буй. Ялангуяа энэ талаарх Аристотелийн ёс зүйн үзлийг нарийвчлан судлах нь ёс зүйн онолын судалгаанд чухал юм. Энэ тухай германы философич Готфрид Вильгельм Лейбниц бичихдээ: “Цицерон болон гэгээн Фома, бусад их сэтгэгчид Аристотелийг огт худал хуурмагаар магтаагүй гэдгийг би олж тогтоосон. Ёс суртахууны талаар түүний бичсэн зүйлүүд нэн гайхалтай сайхан бөгөөд амьдралын туршлагаас авагджээ. Эдгээр нь бас хуульчдад ач тустай юм. Ийм болохоор олон нийтийн үйлсэд оролцохоор зэхэж байгаа тэрхүү залуу хүмүүс үүнийг ойлгож эзэмших ёстой”¹ гэжээ.

Оросын философич А.А.Гусейнов бичихдээ: “...ёс суртахууны агуу онолчдын ёс зүйг энэ ёс зүй бүрэлдсэн механизмын үүднээс авч үзвэл сайн үйлтэн нарын ёс зүй гэж тэмдэглэж болох юм. Энэ ёс зүй бол бие хүн өөрийгөө сахилгажуулж, үйлдлээ зан суртахууны загвартай болгох бололцоо, чадвар бүхий байхад үндэслэдэг. Хүн ёс суртахуунлаг болохын тулд түүнд юу шаардлагатай вэ? Хүсэл эрмэлзлийн хүч, чин сэтгэл хоёр чухал. Аливаа хүн биеэ барьдаг байж, ойр тойрныхондоо туслахад ямагт бэлэн байх ёстой. Нийгэм ёс суртахуунлаг байхын

¹ Готфрид Вильгельм Лейбниц. Сочинения в 4-х томах. Т.1 М., 1982. с. 194

тулд юу чухал вэ? Үүний тулд аль болох олон хүн, алсдаа хүн бүхэн сайн үйлтэн болсон байх ёстой”² гэжээ. Тэгэхдээ ёс суртахууны томоохон онолчид хүн төрөлхтөн бүрэн дүүрэн сайн үйлд хүрч чадаагүй гэж үзээд, сайн үйлийн ёс зүйг ёс суртахууны ямар сайшаал ба хоригоор бататгах ёстойд анхаарлаа хандуулж ирсэн хэмээн А.А.Гусейнов түүхчилэн авч үзсэн байдаг. Ингэхдээ нэн түрүүнд сайн үйлийн тухай Аристотелийн үзлийг онцолсон буй.

Аз жаргал гэж юу вэ, түүний үнэ цэнэ юунд орших вэ? Аз жаргалтай байх нь юунаас хамаардаг вэ? Аз жаргал нь ёс суртахуунаас хамаардаг уу? Аз жаргал хувь хүнээс өөрөөс нь хамаардаг уу? Аз жаргал нь нийгмээс хамаардаг уу? Бид аз жаргалтай амьдралд хүрэх боломж, арга зам байна уу? Сайн үйл гэж юу вэ? Сайн үйл гэж юу вэ гэдгийг мэдэх төдийгүй, бас ямар аргаар түүнд хүрч болох вэ гэдгийг мэдэхийн тулд сайн үйлийг судлах хэрэгтэй. Учир нь сайн үйлийн тухай тодорхой ойлголтуугээр сайн үйлтэн болж чадахгүй. Хувь хүний болон нийгмийн амьдралд сайн үйлийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдол юунд орших вэ? Аз жаргал ба сайн үйлийн харилцан холбоог юугаар тайлбарлаж болох вэ? зэрэг олон асуултанд философи, ёс зүйн үүднээс тодорхой хариултыг өгсөн хүний нэг бол Аристотель юм.

Юуны өмнө аз жаргал болон сайн үйлийн талаарх Аристотелийн үзэл баримтлалын үзэл санааны эх сурвалжийн талаар товчхон авч үзье. Аз жаргал болон сайн үйлийн тухай Аристотелийн ёс зүйн үзэл баримтлал бүрэлдэн төлөвшихөд эртний грекийн философич Сократ, Платоны үзэл нөлөөлсөн. Тухайлбал, Сократын үзлээр, “Ёс суртахууны мэдлэг нь мэдлэгийн бусад хэлбэрээс илүү үнэ цэнэтэй. Аз жаргал бол эд хөрөнгө, эрх мэдэл, зугаа цэнгэл биш, харин саруул ухаан, сайн үйлтэй илүү их холбоотой юм. Хүний амьдралын утга учир нь дээд сайн сайхан болох аз жаргалд хүрэх явдал мөн”³. Ийнхүү аз жаргал нь хүний ёс суртахуунаас хамаардаг. Энэ нь аз жаргалтай байхын тулд ёс суртахуунлаг байх хэрэгтэй гэсэн санааг илэрхийлж байна. Түүний үзлээр, аз жаргал сайн үйлтэй гарцаагүй холбогддог. Цэцэн, эрэлхэг зориг, төлөв зан, шударга ёс гэсэн дөрвөн сайн үйлийг тэрээр онцолж байжээ. Ийнхүү тэрээр ёс суртахуунлаг хүн илүү аз жаргалтай байна гэсэн үзэл санааг анх дэвшүүлсэн түүхтэй.

Сайн үйлийн тухай Сократын үзэл нь харьцангуй сайн үзэл боловч алдаатай үзэл хэмээн Аристотель шүүмжилж хэлэхдээ: “Сократ сайн үйлийг мэдлэгтэй адилтгасан нь сэтгэл санаан дахь оюун ухааны гаднах хэсгийг, түүнтэй хамт хүний хүсэл шуналыг илэрхийлдэг сэтгэлийн хөдөлгөөнийг ч, улмаар зан аашийг ч сайн үйлтэй холбогдолгүй болгосон. Ийм болохоор сайн үйлийг үзэх түүний үзэл буруу ажгуу”⁴ гэжээ.

Түүнчлэн Аристотель сайн үйлийн тухай Платоны үзлийг шүүмжлэхдээ: “Дараа нь Платон гарч ирэв, тэрээр сэтгэл санааг оюун ухааны болон оюун ухааны гаднах гэсэн хэсгүүдтэй гэж хуваагаад, хэсэг бүр нь өөртөө нийцсэн сайн үйлтэй хэмээн үзсэн нь зөв байлаа”⁵ гэжээ. Гэхдээ тэрээр сайн үйлийг дээд сайн сайхны тухай өөрийнхөө сургаалтай хутгасан нь түүний алдаа болсон, яагаад гэвэл, түүний хэлдэг дээд сайн сайхан бол мөн биеэрээ байгаа сайн үйлтэй хамаагүй юм хэмээн Аристотель Платоныг шүүмжилжээ.

Ийнхүү Аристотель аз жаргал болон сайн үйлийн тухай эдгээр философичдын үзэл санааг шүүн шинжилж, улмаар шинэ агуулга, үзэл санаагаар баяжуулсан байна. Тэрээр аз жаргалын тухай ойлголтыг “Никомахын ёс зүй”, “Евдемийн ёс зүй” зохиолууддаа өргөн агуулгаар тайлбарласан буй. Аристотель “Аз жаргал нь сайн үйлийн ёсоор амьдрахад

² А.А.Гусейнов. *Великие моралисты*. М., 1995. с. 264

³ Ф.Х.Кессиди. *Сократ*. УБ., 2004. 133 дахь тал

⁴ Аристотель. *Дээд суртахуун - Б.Даш-Ёндон. Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж боть-II*. УБ., 2011. 21 дэх тал

⁵ Мөн тэнд.

оршино”⁶, “Сайн үйл бол ёс суртахууны суурь мөн”⁷ гэжээ. Сайн үйлийг сэтгэл ханамж дагадаг учраас аз жаргалд хүргэдэг. Ийнхүү бид сайн үйлээр амьдарснаараа аз жаргалтай байж чадна.

Түүний үзлээр, “Сайн үйлээр амьдрахад л зорилго, аз жаргал, дээд сайн сайхан оршино. Дээд сайн сайхан бол аз жаргал мөн, тэгээд тэр нь зорилго мөн, харин төгөлдөр зорилго үйл ажиллагаагаар хэрэгжих учраас сайн үйлээр амьдарснаараа бид аз жаргалтай байж, дээд сайн сайхныг эзэмдэх юм. Түүнчлэн аз жаргалыг, нэг хэсэг нь сайн үйл гэж боддог, нөгөө хэсэг нь ухаан зарах сэтгэлгээ, гуравдах нь мэргэн ухаан гэж санадаг. Ингэхлээр бидний тодорхойлолт аз жаргалыг сайн үйл юм уу эсвэл, ямар нэгэн тодорхой сайн үйл мөн гэж үздэг хүмүүсийн санал бодолтой нийцэж байна. Учир нь сайн үйлд нийцсэн үйл ажиллагаа л сайн үйлийн гол шинж болдог”⁸. Ийнхүү тэрээр аз жаргалын тухай ойлголт харьцангуй олон янз болох тухай, ямар ч тохиолдолд аз жаргалд хүрэх арга зам нь сайн үйл байдгийг онцолсон буй. Энэ бүхнээс үзвэл Аристотель аз жаргалыг сайн үйл, мэдлэг, сэтгэл ханамж зэрэг олон зүйлтэй холбон цогц байдлаар авч үзснээрээ онцлог юм.

Аристотель нь аз жаргалын тухай эвдемонист үзэл санааг уламжлахын зэрэгцээ өргөжүүлэн гүнзгийрүүлж судалсан билээ. Түүний үзлээр “Аз жаргал бол дээд сайн сайхан мөн. Сэтгэл санааны сайн үйлийн ачаар бид сайхан амьдарч болох юм. ... сайхан амьдрах гэдэгт аз жаргалтай амьдрал, аз жаргал оршино, харин сайхан амьдарна гэдэг нь сайн үйлээр амьдарна гэсэн үг. Сайн үйлээр амьдрахад л зорилго, аз жаргал, дээд сайн сайхан оршино.”⁹ Энд бид сайхан амьдрахыг бүгд хүсдэг бөгөөд тэр зорилгоо хэрэгжүүлэх буюу аз жаргалтай амьдралын үндэс нь сэтгэл санааны сайн үйл болохыг тэрээр онцолсон юм.

Хэрхэн аз жаргалтай амьдрах вэ? Аристотелийн үзлээр аз жаргалд хүрэх арга зам нь сайн үйл бөгөөд хүн сайн үйлийг үйлдэж байж л аз жаргалд хүрч чадна. Аз жаргалын мэдрэмж нь өөрөө сайн сайхан зүйл мөн. Аз жаргалтай хүмүүс бусдад илүү санаа тавьдаг, нийгмийн идэвхтэй, бүтээлч, хариуцлагатай, бусдыг эерэгээр хүлээн авдаг. Аз жаргал нь хүнийг аминч болгодоггүй, хэт аминч хүмүүст ихэнхдээ аз жаргал бага байдаг.

Аз жаргалын чухал эх сурвалж нь бусдын эрх ашгийг эрхэмлэх сэтгэл, бусдын сайн сайхан, аз жаргалд чин сэтгэлээсээ анхаарал тавих явдал билээ. Бусдын аз жаргалд санаа тавьсан сэтгэлээр бид тэдэнд аль болох туслахыг хүсэж, тэдэнд гэм хор хүргэх ямар нэг зүйлээс зайлсхийдэг. Энэ нь харилцан хүндэтгэл, итгэлцэл бүхий нөхөрлөлийг бий болгож, бидний амьдралыг улам утга учиртай болгодог сайн үйл болно.

Сайн үйл гэж юу вэ? Аристотелийн ёс зүйн нэг үндсэн ойлголт нь сайн үйлийн тухай ойлголт юм. Энэ талаар Б.Даш-Ёндон “Сайн үйл гэдэг ойлголтыг Аристотель ёс зүйн гурван зохиолдоо бусад ойлголтуудаасаа илүү дэлгэрэнгүй авч үзсэн байдаг.”¹⁰ хэмээн өгүүлсэн буй. Тухайлбал, Аристотель “Дээд суртахуун” зохиолдоо сайн үйлийн тухай асуудлыг илүү дэлгэрэнгүй авч үзжээ.

Түүний үзлээр сайн үйл нь оюунлаг сайн үйл, сэтгэлийн буюу ёс суртахуунлаг сайн үйл гэсэн хоёр хэлбэрт хуваагдана. Оюунлаг сайн үйлд нь ухаалаг сэтгэлгээ, холыг харах ухаан, мэргэн ухаан, суралцах чадвар, ой ухаан гэх мэт зүйл хамаарна. Харин сэтгэл санааны хүсэл зоригийн хэсэгтэй холбогдсон ёс зүйн сайн үйлд тохитой ухаан, шударга ёс, эр зориг болон сайшаалыг хүлээдэг зан авирын бусад шинж хамаардаг ажээ. Ийнхүү сайн үйлийн агуулгад

⁶ Аристотель. Дээд суртахуун - Б.Даш-Ёндон. Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж боть-II. УБ., 2011. 28-29 дэх тал

⁷ Мөн тэнд. 156 дахь тал

⁸ Аристотель. Евдемийн ёс зүй. Орч. Б.Даш-Ёндон. УБ., 2008. 33 дахь тал

⁹ Аристотель. Дээд суртахуун - Б.Даш-Ёндон. Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж боть-II. УБ., 2011. 28 дахь тал

¹⁰ Б.Даш-Ёндон. Аристотелийн ёс суртахуун-улс төрийн философи –Аристотель ба орчин үеийн философи сэтгэлгээ. / Аристотелийн мэндэлсний 2400 жилийн ойд зориулав./ УБ., 2016. 11 дэх тал

ухаалаг байх, алсын хараатай байх, мэргэн ухаан, суралцах чадвар, ой ухаан, төв голч байх, шударга байхыг чухалчилсан байна.

Тэрээр “Үлэмж сайханд чиглэсэн, шүүн бодохуйтай нэгдсэн тэмүүлэл хамгийн шилдэг нь; ийм тэмүүлэл бол сайн үйл мөн”¹¹ хэмээн тэмдэглэсэн байдаг. Ийм сайн үйлийн үр дүнд л аз жаргалд хүрэх боломжтой бөгөөд аз жаргал бол урт хугацаанд эрүүл, сэтгэл амгалан, амьдралдаа сэтгэл хангалуун байх мэдрэмж юм.

Ийнхүү Аристотель сайн үйлийг хүний хүсэл тэмүүлэл, амьдралын зорилготой холбон тайлбарлахдаа: “Сайн үйлийн зорилго нь үлэмж сайн сайхан, энэхүү үлэмж сайн сайхан бол аз жаргал мөн”¹² гэжээ. Тэрхүү үлэмж сайн сайханд хүрэх зорилго нь хувь хүний үйл ажиллагаагаар хэрэгжих учраас сайн үйлийг эрхэмлэж амьдарснаараа хүн илүү их аз жаргалтай байна гэсэн үзэл санааг дэвшүүлсэн байна. Эндээс үзвэл, аз жаргал бол хүний амьдралын зорилго, ёс суртахууны үнэт зүйл юм. Түүний үзлээр “Хамгийн өргөн утгаар сайн үйл гэдэг хамгийн сайн төлөв байдал мөн”¹³. Аз жаргалтай амьдаръя гэвэл бид сайн, мууг ялгаж, сайныг эрхэмлэж хүн төрхтэй явах учиртай. Аз жаргалтай амьдаръя гэвэл хүний орчлонд зүй зохистой харьцах харилцаа чухал.

Хүний амьдралын зорилго бол аз жаргалтай амьдрах явдал гэж тэрээр үзээд “Аз жаргал гэдэг бол сайн үйлд нийцсэн сэтгэл санааны тодорхой чанар бүхий үйл ажиллагаа бөгөөд аз жаргалтай амьдрахын тулд ...сайн үйлд суралцах хэрэгтэй”¹⁴ хэмээн тэмдэглэсэн буй. Ийнхүү аз жаргал бол үйл ажиллагаа мөн бөгөөд түүнд хүрэхийн тулд хүн сайн үйлийн ёсоор идэвхтэй үйл ажиллагааг өрнүүлдэг байх шаардлагатай.

Түүний үзлээр, “Сайн үйл нь төрөлхөөс өгөгдсөн чанар биш, олж авдаг чанар” юм. Тэгэхээр түүний хувьд сайн үйл нь хүний үйл ажиллагаатай холбоотой, дадал зуршлаар бий болсон олдмол шинж юм. Сайн үйл бол олдмол шинж гэх энэ үзэл нь тэр үеийн ёс суртахууны философид бий болсон цоо шинэ үзэл хараахан биш юм. Учир нь Аристотелиос өмнө Платон сайн үйлийг жинхэнэ дээд сайн үйл, жирийн сайн үйл гэж хоёр янзаар тайлбарласан байдаг. Платоны үзлээр, жирийн сайн үйл нь зөв аж төрөх ёс, хүмүүжлийн ачаар бий болно. Хэдийгээр Аристотель сайн үйлийн тухай Платоны үзлийг шүүмжилдэг боловч, жирийн сайн үйлийн тухай авч үзсэн Платоны үзлийг тэр ёс суртахууны философийн үзэлдээ тодорхой хэмжээгээр уламжилсан нь эндээс харагддаг.

“Евдемийн ёс зүй”¹⁵ бүтээлдээ сайн үйл бол сэтгэл санааны хамгийн шилдэг хөдөлгөөнөөр төрж гардаг, сэтгэл санаанд хамгийн шилдэг үйлдэл, мэдрэхүйг буй болгодог төрх төлөв болох талаар тэрээр авч үзжээ. Мөн энэ зохиолын гуравдугаар дэвтэртээ тэрээр эр зориг, тохитой ухаан, даруу зан, уужим сэтгэл, өгөөмөр зан зэрэг сайн үйлийн бодит үзэгдлүүдийг нэг бүрчлэн дэлгэрэнгүй тайлбарласан нь өнөө үеийн хүмүүст танин мэдэхүйн ихээхэн ач холбогдолтой байна.

Харин энэ бүтээлийн тавдугаар дэвтэртээ тэрээр оюунлаг сайн үйлийн талаар гүнзгийрүүлэн тайлбарлажээ. Түүний үзлээр, “Ухаан зарах сэтгэлгээг сайн үйл лүгээ нэгтгэх нь ёс суртахуунлаг авир үйлдэлд зайлшгүй чухал бөгөөд ухаан зарах сэтгэлгээ болон мэргэн ухаан нь сайн үйлийг хэрэгжүүлэх үндэс болдог”¹⁶ ажээ. Ухаан зарах сэтгэлгээ бол сэтгэл санааны сайн үйлийн нэг юм. Ухаан зарах сэтгэлгээгүйгээр зөв сонголт хийж чадахгүй. Иймд ухаанд захирагдсан амьдрал л хамгийн аз жаргалтай юм. Ер нь хүнийг ухаан зарж амьдар хэмээн оюун ухаан заяасан билээ. Ухаалаг байх нь олон талын ач тустай.

¹¹ Аристотель. Дээд суртахуун. Орч. Б.Даши-Ёндон. 2008. 60 дахь тал

¹² Мөн тэнд. 38 дахь тал.

¹³ Аристотель. Никомахын ёс зүй. Орч. Б.Даши-Ёндон. УБ. 2007. 116-117 дахь тал.

¹⁴ Мөн тэнд. 31 дэх тал.

¹⁵ Аристотель. Евдемийн ёс зүй. Орч. Б.Даши-Ёндон. УБ., 2008

¹⁶ Аристотель. Евдемийн ёс зүй - Б.Даши-Ёндон. Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж боть-II. УБ., 2011. 530 дахь тал

Хүний сайн сайхан нь сайн үйлтэй нийцсэн сэтгэл санааны үйл ажиллагаанд оршино гэж тэрээр үзэж байсан. Аристотель “Хувь хүний бүхий л үйлдэл, амьдралынх нь хэв маяг нь түүний өөрийнх нь ёс суртахуунтай холбоотой, өөрөөр хэлбэл хүний ёс суртахуун үйлдлээр нь илэрдэг”¹⁷ гэжээ. Хүмүүс янз бүрийн ааш зан гаргадаг болохоор нэг хэсэг нь тохитой томоотой, нөгөө хэсэг нь уур хилэн ужид самуунд баригдсан хүмүүс болдог. Тэгэхээр нэг л адил ааш үйлдлийг давтаад байвал түүнд тохирсон ёс суртахууны суурь тогтдог.

Тиймээс аливаа зүйлийг сурч эзэмшиж өөрийн болгож авахад зуршил, дадал хэвшил чухал болохыг ёс зүйн бүтээлдээ дурдаж хүн бүрт боломж буйг сануулж байсан нь орчин үеийн олон судлаачийн бүтээлд ч томоохон байр суурийг эзэлсээр байна. Тэрбээр ёс суртахууны зуршил сайн биш бол тэр нь ёс суртахууны мэдлэгийг хүлээн авахад саад болно гэж үзээд, хүн сайн үйлийг үйлдэх зуршлыг үргэлж үйлдэж байх ёстой хэмээн үзэж байсан. Эндээс үзэхэд сайн үйлд мэдлэгээс гадна хүмүүжил дадал зуршил их чухал ажээ.

Сайн үйлийн тухай асуудлыг тайлбарлахдаа тэрээр алтан дундажийн зарчмыг боловсруулсан юм. Аристотель ёс суртахууны сайн үйлийн гол шинжийг тайлбарлахдаа алтан дундажийн тухай (golden mean) үзэл санааг боловсруулсан. Аристотель сайн сайхан бол хүнээс өөрөөс нь хамаарна хэмээгээд, сайн үйлийг бүтээхэд аливаа зүйлд авах гээхийн ухаанаар хандах буюу юмсын хэмжээ зохис, тэнцвэрт байдлыг чухалчилж, үүнийгээ хүний зан чанартай холбож тайлбарласан бөгөөд илүүдүүлэлт буюу дутуудуулалтгүйгээр алтан дундажийг баримтлах нь сайн үйл хэмээн томъёолсон.

Түүний ёс зүйн сургаал дахь тэнцвэрт байдал буюу зохист байдал нь улам нарийсаж хүн өөртөө буюу, сайн үйл өөртөө хэмжүүртэй байх тухай санааг хэлж, хүмүүсийн зан суртахууны илрэлүүдээс хэмжээ зохист буюу дундаж байдлыг эрхэмд үзэхийг санал болгосон байдаг¹⁸. Түүний үзэж буйгаар, сайн үйл бол тодорхой хэмжээний дундаж мөн.

Тэрээр хүний аливаа үйл хэрэг, зан чанарт байх хамгийн чухал зарчим нь “Дундаж” буюу юмсын хэмжээ зохирол, тэнцвэрт байдал бөгөөд энэхүү дундажийн зарчмыг баримтлах нь сайн үйлийн салшгүй хэсэг юм гэдгийг анхааруулсан байдаг. Дундажийн зарчим нь түүний боловсруулсан сайн үйлийн тухай сургаалд ихээхэн ач холбогдолтой.

Түүнчлэн тэрхүү дундаж байдлаар илэрч буй шударга ёс, эр зориг, найрсаг зан гэх зэрэг нь сайн үйлийн илрэх хэлбэр гэж хэлж болно. Аристотель дундажид илүүдэх эсхүл дутуудахыг сөргүүлэн тавьдаг нь хоёр шалтгаантай гэж үзжээ. Түүний үзлээр “Нэг тохиолдолд уг юм дундажид ойрхон байна уу, хол байна уу гэж түүн рүү өөр рүү нь харцгаадаг, жишээ нь, өгөөмөр чанараас үрэлгэн байдал нь хол байна уу, харамч хясуу байдал нь хол байна уу гэж; ингэхэд, өгөөмөр чанартай үрэлгэн байдал нь харамч татуугаасаа илүү төстэй байдаг, ингэхээр харамч татуу нь өгөөмөр чанараас хол байна, ингэхээр, дундажаас илүү хол байгаа тэр зүйл дундажид илүү эсрэгцсэн байдалтай байж таарна, энэ тохиолдолд дутуудах нь дундажид илүү их эсрэгцэн байгааг харуулж байна.

Нөгөө талаас илүүтэй ихээр байгалиас заяагдсан тэр зүйл нь дундажид илүү сөрөг байдаг гэнэ. Тухайлбал, цэгц хэмийг бодоход зах замбараагүй чанар бидэнд илүү ихээр заяагджээ. Бидэнд илүүтэйгээр заяагдсан тэр тал руугаа л бид илүү хэлбийдэг, тэгээд бид юу руу илүү хэлбийх тусмаа [дундажид] тэр хэмжээгээрээ илүү сөрөг болдог; ингэхээр, бид цэгц хэмийг бодоход зах замбараагүйд илүү автагддаг; ингэхээр, [энэ тохиолдолд] илүүдэл дундажид хамгийн их сөрөг байна”¹⁹ гэж тайлбарласан буй.

Энэ бүхнээс дүгнэн хэлэхэд: Аз жаргал болон сайн үйлийн тухай ойлголт бол Аристотелийн ёс зүйн чухал судлагдахуун юм. Аз жаргал бол сайн үйл хийж, бидний сайн

¹⁷ Аристотель. Дээд суртахуун. Орч. Б.Даш-Ёндон. УБ., 2006. 8-9 дэх тал.

¹⁸ Р.Дарьхүү. П.Мягмарсайхан. Сайн үйлийн тухай Аристотелийн үзэл ба орчин үе- “Аристотель ба орчин үеийн философи сэтгэлгээ”. УБ., 2016. 25 дахь тал

¹⁹ Аристотель. Дээд суртахуун. Орч. Б.Даш-Ёндон. УБ., 2006. 27-28 дахь тал

сайхан амьдарч байгаагийн үр дүн, Аз жаргал бол тухайн хүний амьдрал утга учиртай байгаа эсэх тухай асуудал мөн. Амьдралынхаа утга учир, зорилгыг ухамсарласан, түүнийхээ төлөө ажиллаж, амьдарч, тэмцэж байгаа хүний амьдрал л аз жаргалтай байж чадна.

Сайн үйл бол хувь хүний сэтгэлийн болон оюун санааны эерэг зан чанарууд, тэдгээрийн илрэл болсон ёс суртахуунлаг үйлдлийг илэрхийлдэг ойлголт юм. Сайн үйлийн зорилго нь үлэмж сайхан юм. Аз жаргалтай амьдрах ба сайн үйлтэн болох нь бидний ёс суртахууны ухамсараас илүү их хамаарна.

Аз жаргал ба сайн үйл бол хүний амьдралын үнэт зүйлс юм. Бусдын төлөө ухаан зарж, сэтгэл зүрхээ зориулж хийсэн сайн үйл болгон үнэ цэнтэй бөгөөд аз жаргалд хүргэнэ. Сайн үйлд жижиг зүйл гэж байдаггүй. Бага гэлгүй, сайхан сэтгэлээр сайн үйлийг алхам алхмаар бүтээх хэрэгтэй. Аз жаргал нь сайн үйлийн ёсоор амьдрахад оршино. Мөн сайн үйлд мэдлэгээс гадна хүмүүжил дадал зуршил чухал. Сайн үйл гэдгийг ярих нэг хэрэг, түүнийг амьдрал, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх нь олон талын ач тустай. Сайн үйлд ёс суртахууны хүмүүжил чухал үүрэг гүйцэтгэдэг.

Сайн үйлд суралцаж буй хүн зөв үйлдлүүдийг хийж сурах ёстой ба тэгж байж л сайн үйлдлийг гүйцэтгэдэг болно. Гэвч сайн үйл бол бүхий л дадал зуршил биш. Гагцхүү эерэг дадал зуршил бол сайн үйлийг хөгжүүлэхэд туслах зүйл бөгөөд хүний жинхэнэ сайн үйлтэй үгүй нь түүний ёс суртахууны сонголтоор илэрдэг. Өөдрөг үзэлтэн аливаа хүнд хэцүү нөхцөл байдалд зөвхөн боломжийг нь олж хардаг, гутранги үзэлтэн аливаа боломж гарах болгонд бэрхшээлийг нь олж хардаг.

Ийнхүү аз жаргал болон сайн үйлийн тухай Аристотелийн үзэл баримтлалд сайн сайхан амьдралын утга учир ба хүн яаж сайн амьдрах арга ухааныг өргөн агуулгаар авч үзсэн бөгөөд үүнд энэхүү сургаалийн орчин үеийн ач холбогдол оршино. Тэртээх олон зууны өмнө бүтээж туурвиж байсан аз жаргал ба сайн үйлийн тухай Аристотелийн сургаал өнөө ч хуучирч мартагдсангүй, эрхэм үнэтэй байсаар байна.

Өнөө үед хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм төлөвшин тогтоход сайн үйл чухал үүрэгтэй. Д.Тунгалагийн хэлснээр, “Аристотель нийгмийг төгөлдөржүүлэхэд ёс зүйн сургаалаа зориулсан болно.”²⁰ Сайн үйл ба аз жаргал нь хувь хүний болон нийгмийн хөгжлийн нэг гол нөхцөл төдийгүй нийт нийгмийн харилцааг зохицуулагч, чиглүүлэгч нэг арга хэрэгсэл билээ. Иймд өнөөгийн нийгэмд аз жаргал ба сайн үйл гэж юу болох, тэдгээрийн агуулга, ач холбогдол, үнэ цэнийн талаар сургалт, судалгаа, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх нь чухал хэмээн үзэж байна.

Ёс зүйн суурь асуудал болсон «Би хэрхэн аз жаргалтай, сайн сайхан амьдрах вэ» гэдэг асуудлыг анх Сократ дэвшүүлж, 2400 жил үргэлжилсэн энэхүү асуултад цөөн бодит хариулт өгсөн гэж хэлж болно. Тийм бодит сайн хариулт өгсөн хүмүүсийн нэг бол Аристотель мөн. Түүний үзлээр, аз жаргал болон сайн үйлийн тухай ойлголтын гол утгань хүний сайн зан чанарын хамгийн дээд зэргээр илрэх байдлыг харуулсан амьдралын хэв маяг юм. Тэрээр аз жаргал болон сайн үйлийн тухай ойлголтуудын агуулгыг хамгийн дэлгэрэнгүй судалсан. Тэрээр аз жаргал, сайн үйл, сайн сайхан зэргийг бичихдээ, хүний амьдралын зорилго бол аз жаргалтай амьдрах бөгөөд аз жаргалтай байхын тулд сайн сайхан зүйл рүү тэмүүлж, сайн үйлд суралцах гэж тэдгээрийн холбоо хамаарлыг онцлон үзжээ. Сайн үйл бол хүний амьдралын зорилгот шинжтэй холбоотой бөгөөд сайн сайхан амьдралын цөм юм.

Бид аз жаргалтай амьдрахыг нэн тэргүүнд эрхэмлэх ёстой. Аз жаргалын үндэс бол аливаа зүйлийг өөдрөг байдлаар харах сэтгэлийн болон оюун ухааны чадвар юм. Аз жаргалтай амьдрахад материаллаг зүйлсээс илүү сэтгэлийн, оюун ухааны хүчин зүйл их

²⁰ Д.Тунгалаг. Аристотелийн “Никомахын ёс зүй” зохиол дахь ёс зүйн зарим асуудал – “Аристотель ба орчин үеийн философи сэтгэлгээ”. УБ., 2016. 47 дахь тал

чухал. Аз жаргалтай байх нь амжилтад хүрэхийн үндэс. Аз жаргал бол урт хугацаанд эрүүл, аз жаргалтай, сэтгэл амгалан, амьдралдаа сэтгэл хангалуун байх мэдрэмж юм.

Аз жаргал ба сайн үйлийн тухай **Аристотелийн** үзэл баримтлал нь ёс зүй бол аз жаргал ба сайн үйлд үндэслэх ёстой хэмээх үзэл юм. Энэхүү үзэл баримтлал хувь хүн болон хамт олны зүгээс муу үйлээс сэргийлэх, сайн сайхан амьдралын төлөө хамтран ажиллах, хүмүүнлэг иргэний нийгэмд аж төрөхөд чухал ач холбогдолтой.

ABSTRACT

Aristotle (384–322 B.C.E.) numbers among the greatest philosophers of all time. Concepts of happiness and virtue are the main subjects of the ethical teaching of Aristotle. Happiness is the ultimate end and purpose of human existence. Happiness is not pleasure, nor is it virtue. It is the exercise of virtue. Happiness is the perfection of human nature. Since man is a rational animal, human happiness depends on the exercise of his reason.

According to Aristotle, the good life is the happy life, as he believes happiness is an end in itself. Aristotle develops a theory of the good life, also known as happiness, for humans. Happiness is perhaps best translated as flourishing or living well and doing well. The meaning of well being and how to have good life discussed in a broad way and it is the contemporary significance of this view.

НОМ ЗҮЙ

1. Аристотель. Евдемийн ёс зүй. Орч. Даш-Ёндон. УБ., 2008
2. Аристотель. Никомахын ёс зүй. Орч. Даш-Ёндон. УБ., 2007
3. Аристотель. Дээд суртахуун. Орч. Даш-Ёндон. УБ., 2006
4. А.А.Гусейнов. Великие моралисты. М., 1995.
5. Р.Дарьхүү. Ёс зүйн асуудлууд. УБ., 2015
6. Р.Дарьхүү. П.Мягмарсайхан. Сайн үйлийн тухай Аристотелийн үзэл ба орчин үе- “Аристотель ба орчин үеийн философи сэтгэлгээ”. УБ., 2016
7. Р.Дарьхүү. Э.Хулан. Аристотелийн “Дээд суртахуун” зохиол дахь сайн үйлийн тухай үзэл баримтлал” - “Философи, шашин судлал” сэтгүүл. № 385. ХИҮ. УБ., 2013
8. Б.Даш-Ёндон. Аристотелийн ёс суртахуун-улс төрийн философи – “Аристотель ба орчин үеийн философи сэтгэлгээ”. УБ., 2016
9. Б.Даш-Ёндон. Эртний грекийн философи сэтгэлгээний эх сурвалж. II боть. УБ., 2011.
10. Готфрид Вильгельм Лейбниц. Сочинения в 4-х томах. Т.1 М.,1982
11. Д.Тунгалаг. Аристотелийн “Никомахын ёс зүй” зохиол дахь ёс зүйн зарим асуудал – “Аристотель ба орчин үеийн философи сэтгэлгээ”. УБ., 2016.
12. Э.Хулан. Сайн үйлийн тухай ёс зүйн ойлголт: уламжлал ба орчин үе. Магистрын зэрэг горилсон бүтээл. УБ., 2013